

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц

“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ хүрээнд:

Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хувьд:

Дэд хөтөлбөрийн 5.4 тэрбум төгрөгийн гурав дахь зээлийн шугамыг Худалдаа Хөгжлийн банкинд 1 жилийн хугацаатайгаар 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нээж, нөөцийн менежер уг эх үүсвэрийг зориулалтын дагуу ашиглаж эхлээд байна.

“Гурилын үнийг тогтворжуулах” хөтөлбөрийн хувьд:

ҮХААЯ-аас гурилын үйлдвэрүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, шалгуур үзүүлэлтүүдийг баталж, гурилын үйлдвэрүүдийн материалуудыг хүлээн авч, шалгаруулалтыг зохион байгуулах, гэрээ байгуулах, Монголбанкнаас банкуудтай дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулах ажлуудыг тус тус гүйцэтгэж байна.

Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр” цэснээс үзнэ үү. <http://www.mongolbank.mn/pricestability.aspx>